

ҮНЭТ ЦААСНЫ ХУВААРИЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Базальт ХК нь олон нийтэд 16,925,100 ширхэг хувьцааг санал болгож 6.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зорьж байна.

Энэ хүрээнд хувьцааны захиалга нь 2 үндсэн нөхцөлөөр зааглагдах бөгөөд аль ч нөхцөлөөр авах эрх бүгдэд нээлттэй байна.

1/ 3.0 тэрбум төгрөгийн (7,894,740 ширхэг) хувьцаа нь **хязгаарлалтгүй арилжаанд оролцох эрхтэй** хувьцаа байх буюу IPO амжилттай болсон даруйд хоёрдогч зах зээлийн эргэлтэнд орох боломжтой байна. Энэхүү нөхцөлийг зөвшөөрсөн Анхдагч зах зээлийн худалдан авах захиалгын хэмжээ нийлүүлэлтээс давсан тохиолдолд дараах хүснэгтэд заасны дагуу хөрөнгө оруулагчдын тооноос хамааран харгалзах хэмжээг 100 хувь биелүүлж түүнээс дээш гарсан мөнгөн дүнд хувь тэнцүүлэн хуваарилна.

Суурь хувиарлалт хийх Мөнгөн Дүн	Биелэх мөнгөн дүн	Хувь тэнцүүлэгдэх мөнгөн дүн	Биелэх мөнгөн дүн
1.0 тэрбум төгрөг	Нийт захиалга өгсөн хүний тооноос хамаарна	2.0 тэрбум төгрөг	Нийт захиалгын мөнгөн дүнд харьцуулж, хувь тэнцүүлнэ.

2/ 3.4 тэрбум төгрөгийн (9,030,360 ширхэг) нь хязгаарлалттай буюу 6 сарын хугацаанд **арилжаанд оролцох эрхгүй** байх нөхцөлийг зөвшөөрсөн хөрөнгө оруулагчдад санал болгох хувьцаа байх буюу IPO амжилттай болсонд тооцогдсоны дараах 6 сарын хугацаанд хоёрдогч зах зээлийн эргэлтэнд орох боломжгүй байна. Энэхүү захиалгын онцлог нь илүү өндөр биелэлтийн хувийг санал болгохоороо урт хугацаанд хөрөнгө оруулах гэж буй хөрөнгө оруулагчдад давуу талтай.

Энэхүү нөхцөлийг зөвшөөрсөн Анхдагч зах зээлийн худалдан авах захиалгын хэмжээ нийлүүлэлтээс давсан тохиолдолд дараах хүснэгтэд заасны дагуу хувь тэнцүүлэн хуваарилна.

Хувь тэнцүүлэгдэх мөнгөн дүн	Биелэлт
3.4 тэрбум төгрөг	Нийт захиалгын мөнгөн дүнд харьцуулж, хувь тэнцүүлнэ.